



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/412

Улаанбаатар хот

МУИС-д профессор, багш ажиллуулах
журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, МУИС-ийн Дүрмийн 5.3.9.3, 5.4.1, 5.4.8.5 дахь заалт, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмын 6.1 дэх заалт, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 06/23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-д профессор, багш ажиллуулах журамд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

1.1. МУИС-д профессор багш ажиллуулах журмын 7.8 дахь заалтыг “Профессор болон дэд профессорын албан тушаалд ажиллах багшийг сонгон шалгаруулахдаа ерөнхий болон тусгай шаардлагаас гадна сүүлийн 5 жилд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлыг нь гол шалгуур болгон Хавсралт 1-д (Хүснэгт 2) заасан үзүүлэлтийг ашиглана. Профессорын зэрэглэлд нэр дэвшигч нь доорх хүснэгтэд заасан харгалзах салбарын ангиллын аль нэгээр сүүлийн 5 жилд 2-оос цөөнгүй (тооцуулах 1 ЭШ-ний өгүүлэл 1-р эсхүл холбоо барих зохиогчоор байх) эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн байна.”

Хүснэгт. Эрдэм шинжилгээний бүтээлийн шалгуур үзүүлэлт

Ангилал Салбар	Web of Science IF-JCR бүхий сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл	Scopus CiteScore бүхий сэтгүүл эсхүл хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн өгүүлэл	Монограф ¹	ОУ-ын статустай мэргэжлийн холбоодоос эрхлэн гаргадаг, хянан магадлага бүхий ОУЭШС ²
Байгалийн ухаан, Хэрэглээний шинжлэх ухаан	+			
Инженерийн ухаан, Мэдээллийн технологи	+	+		
Нийгмийн болон хүмүүнлэгийн ухаан	+	+	+	+

1.2. “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-ын 8 дугаар бүлгийг “Багшийн ажлын үнэлгээ” нэртэйгээр шинээр үүсгэн 8.1 дэх заалтад “Багшийн ажлыг дараах 3 чиглэлээр үнэлж (аттестатчилал), тусгай журмаар зохицуулна. Үүнд: а) сургалт, заах арга зүй; б) эрдэм шинжилгээний ажил; в) мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ”, 8.2 дахь заалтад “МУИС-д багшаар 15 хүртэл жил ажилласан бол 3 жил тутамд, 15 ба түүнээс дээш жил ажилласан бол 5 жил тутамд харгалзах хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа багш (аттестатчиллаар) үнэлүүлнэ.

¹ Монограф нь дараах шаардлага хангасан байна:

1. Онолын мэдлэгийн салбарын тодорхой сэдвийг онол арга зүйн хувьд орчин үеийн түвшинд судалсан байх;
2. Эрдэм шинжилгээний бичлэгийн форматын шаардлагыг бүрэн хангаж 8 хэвлэлийн хуудаснаас багагүй хэмжээтэй байх;
3. Тухайн чиглэлийн эрдмийн зөвлөлд монографын эхээ танилцуулан эрдмийн зөвлөлөөс санал болгосон 2-оос доошгүй мэргэшсэн рецензентээр хянуулж тодорхойлолт авсан байх;
4. Тухайн судалгааны хүрээнд гадаад, дотоодын сэтгүүлд (МУИС-д бүртгэлтэй дотоодын сэтгүүл) эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байх;
5. Дээрх шаардлагыг хангасан нөхцөлд нэг эсхүл түүнээс дээш зохиогчтой байж болно.

² Хууль зүйн сургуулийн сэтгүүл дараах шаардлага хангана. 1. Хуулийн мэргэжлийн редакцтай. 2. Хянан магадлагаа /blind peer review/ хийдэг. 3. Англи хэлээр хэвлэгддэг. 4. Хууль зүйн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталсан гадаадын 10 эрдэм шинжилгээний сэтгүүлийг тооцох ба Web of Science, Scopus-д хэвлүүлсэн бүтээлтэй профессор нь шаардлагыг түрүүлж биелүүлсэнд тооцогдоно.

D:tushaal_2023

1423062801

МУИС-ийн дэд профессор/профессор цолтой, МУИС-д багшаар 25-аас дээш жил ажилласан багш 5 жил тутамд гүйцэтгэсэн ажлаараа өөрийн үнэлгээний тайлан бичиж (аттестатчилал) үнэлүүлнэ.”

1.3. “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-ын 13 дугаар бүлэгт 13.8.1 дэх заалтыг “А”, “Б”, “В” цагийн ачаалал тус тусдаа биелэгдсэн бөгөөд А цагийн гүйцэтгэлийг хүн*цагаар тооцон нормоо биелүүлсэн нөхцөлд “А”-ийн илүү цагийн хөлс олгоно. Б-ээс А-д цаг шилжүүлэн нэмэлт цаг гаргахыг хориглох бөгөөд түүнд хөлс олгохгүй. Багшийн тухайн хичээлийн жилийн хүн*цагаар тооцсон нормыг тооцоходоо дараах томъёог ашиглана.

$$X = (A+B)*Ц / (26*T)$$

X - Багшийн тухайн хичээлийн жилийн норм, хүн*цаг

Ц - Тухайн зэрэглэлд ажиллах багшийн жилийн цалин, төгрөг

A - Тухайн зэрэглэлд гүйцэтгэх А цагийн норм, багц цаг

B - Тухайн зэрэглэлд гүйцэтгэх В цагийн норм, багц цаг

T – Ерөнхий суурь хичээлийн 1 багц цагийн төлбөр

1 хүн*цаг гэдэг нь оюутан 1 Бц-ийн хичээл судалсантай дүйцэх нэгжийг хэлнэ.” гэж тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

2. “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг ханган хяналт тавьж ажиллахыг эрхэлсэн захирал (Б.Батжаргал, Б.Баяртогтох, Ч.Энхбаяр, Г.Галбаяр), Захирлын ажлын алба (Н.Баатарбилэг), Хууль, хүний нөөцийн бодлогын газрын дарга (С.Должин), Цахим шилжилтийн бодлогын газрын дарга (А.Баатарбилэг), бүрэлдэхүүн сургуулийн захирал (Д.Заяабаатар, Б.Баяртогтох, Н.Батнасан, Б.Амарсанаа, Б.Батжаргал), салбар сургуулийн захирал (Б.Баяржаргал, Ч.Удвалноров, Д.Алтанхуяг) нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Д.БАДАРЧ